



**ОРХОН АЙМГИЙН  
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 04 сарын 16 өдөр

Дугаар 07/32

Баян-Өндөр сум

**U17, U23 насны улсын аварга шалгаруулах  
тэмцээнд хөрөнгө гаргах  
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2009 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 53/45 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсад олон улс, тив, дэлхийн спортын тэмцээн, наадмыг зохион байгуулах, санхүүжүүлэх журам”-ын 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. U17, U23 насны улсын аварга шалгаруулах тэмцээнд зарцуулагдах төсвийг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтын дагуу санхүүжилтийн гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг спортын хэлтсийн дарга (Э.Лхамсүрэнбаатар), спортын тэмцээн, наадмын бодлогын хэрэгжилт, зохион байгуулалт, тайлагналт хариуцсан мэргэжилтэн (Д.Дашбаатар) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тэмцээнд зарцуулагдах 3,150,000 (гурван сая нэг зуун тавин мянга) төгрөгийг зохих журмын дагуу үндэсний тэмцээн наадмын үйл ажиллагааны зардлаас гаргаж, гэрээний дагуу шилжүүлэг хийхийг ерөнхий нягтлан бодогч, аж ахуйн албаны дарга (Ж.Нямжаргал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Д.ДЭЛГЭРБАЯР

Биеийн тамир, спортын газрын  
2025 оны 04 дугаар сарын 16-ны өдрийн  
10/32 дугаар тушаалын хавсралт

U17, U23 НАСНЫ УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ  
ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ

| Д/д | Спортын<br>төрлийн нэр | Байрны зардал |      |                   | Бүгд (төгрөгөөр) |
|-----|------------------------|---------------|------|-------------------|------------------|
|     |                        | Хүний<br>тоо  | Өдөр | Нэг бүрийн<br>үнэ |                  |
| 1   | Чөлөөт бөх             | 21            | 6    | 25,000            | 3,150,000        |
|     | Төсвийн нийт дүн       |               |      |                   | 3,150,000        |

----oOo----



Боловсруулсан: .....  
Хянасан: .....  
Хувь: .....

*Удирдлага*

*Удирдлага*

815 202 01